

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Тамзавын Баднагарав	Дугаар	Л118
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Өмнөдэлгэр
Төрсөн газар	Өмнөдэлгэр	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хүүхэн хутагтын хүрээ	Сүм хийдийн дугаар	ХЭРД 076
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 2	Ярилцлага авсан хүн	Ж. Одгарьд

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Хүүхэн хутагтын хүрээ

-Та нутаг орондоо байсан хүрээ хийдийн тухай мэдэх зүйлээ хэлж өгөөч?

Хүүхэн хутагтын Жодын хурлын хүрээний эзэн нь хар эрээн могой байдаг. Хүрээний түүрийн чулуунаас авчирч сумд конторын барилгын хундаам барихад тэр чулуунуудыг могой 3 шөнө, 3 өдөр эргэсэн. Тэгээд алга болчихсон. Манай бүрлээч тэр могойг нэг хүн алчихав уу, нутагтаа буцчихав гээд байсан. Цэрэнбалжир гэж манайхны нэг хүүхэн бид хоёр нэг хавар Баяндэлгэрээ тахиад Эрээтийн түүрийг тойроод явж байтал хэрэмний баруун хойд талын булан дороос могой тохой хэртэй гарч ирээд орчихсон. Тэгээд би буурай аавын чинь хэлдэг могой байна гэж хэлсэн. Энэ жил (2007) тахилганд очоод нүхээ харсан байж л байна лээ. Харин жаахан томорчихсон байсан. Арай ухаагүй байгаа? Манайх тэр хийдийн шүтээнийг нь хадгалж байсан болохоор, намайг бурханд нь зул хүж өргөж, идээ цайныхаа дээжийг тавиад байдаг болохоор тэр эзэн нь над нэг харагдав уу гэж бодсон. Манайд Хүүхэн хутагтын хүрээний шүтээн хадгалагдаж байсан. Манай өвгөн тэнд сууж байсан хүн.